

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 12 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар 498/345

Улаанбаатар хот

**СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН САНХҮҮЖИЛТИЙН
АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг тооцох, хуваарилах аргачлалыг нэгдүгээр, Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн суурь зардлын хэмжээг хоёрдугаар, Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн орон тооны жишгийг гуравдугаар, Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн шатахууны зардал тооцоход ашиглагдах индексийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталж, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газар /Р.Оюунханд/, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/, Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 21/41 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ТООЦОХ, ХУВААРИЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийг хуваарилах харилцааг энэхүү аргачлалаар зохицуулна.
- 1.2 Энэхүү аргачлал нь Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжын хүрээнд зохицуулагдана.
- 1.3 Энэхүү аргачлалд заасан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.3.1 “Сум, тосгоны эрүүл мэндийн төв” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 16.7 дугаар зүйл;
 - 1.3.2 “Үйлчлэх хүрээний радиус” гэж Тухайн сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үйлчлэх хүрээний хамгийн алслагдсан зайн хэмжээг /км/;
 - 1.3.3 “Алслалт” гэж Тухайн эрүүл мэндийн байгууллагын оршин байгаа сум, тосгоны төвөөс харъяа аймгийн төв хүртлэх зайн хэмжээг /км/;
 - 1.3.4 “Оршин суугаа хүн ам” гэж Үндэсний статистикийн хорооноос нийтэд мэдээллэсэн тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа суурин хүн амын тоог;
 - 1.3.5 “Бүс” гэж Улсын Их Хурлын 2003 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан эдийн засгийн бүсийг: Баруун, хангайн, Төвийн, Зүүн.
 - 1.3.6 “Сум, тосгоны хүн амын тооноос хамаарсан ангилал” гэж Энэхүү журмын 3.4.2-т заасан ангиллыг;
 - 1.3.7 “Норматив” - гэж Тухайн үйлчилгээ, арга хэмжээнд зарцуулах нөөцийг хуваарилах зорилгоор тооцсон зардлын дундаж хэмжээг;
 - 1.3.8 “Суурь зардал” гэж Тухайн төсөв боловсруулах жилийн нормативаар тооцсон зардлын нийт хэмжээг;
 - 1.3.9 “Замын бартаа” гэж Тухайн сум, тосгоны газар нутгийн далайн түвшнээс дээш өргөгдсөн өндрийн хэмжээг;
 - 1.3.10 “Шатахууны үнийн индекс” гэж Бүс хоорондын шатахууны үнийн дунджын харьцааг;

Хоёр. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үрсгал зардлын бүрэлдэхүүн

- 2.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа явуулах урсгал зардлыг дараах байдлаар ангилна:
 - 2.1.1. хувьсах зардал;

- 2.1.2. байр ашиглалттай холбоотой тогтмол зардал;
- 2.2 Хувьсах зардал нь дор дурдсан зардлаас бүрдэнэ:
- 2.2.1. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил;
 - 2.2.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл;
 - 2.2.3. Хангамж, бараа материалын зардал;
 - 2.2.4. Нормативт зардал;
 - 2.2.5. Эд хогшил, урсгал засварын зардал;
 - 2.2.6. Томилолт, зочны зардал;
 - 2.2.7. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж;
 - 2.2.8. Бараа үйлчилгээний бусад зардал;

Гурав. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал

3.1 Энэхүү аргачлалын 2.1-т заасан урсгал зардлыг дараах аргачлалаар тооцож төсөвт тусгана:

$$TCi = MCi + FCi + Pi + Bi + Si + Ci$$

TCi – тухайн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн жилийн нийт төсөв

MCi – суурь зардал

FCi – байр ашиглалттай холбоотой нийт тогтмол зардал

Pi – хүн амаас хамааран нэмэгдэх нийт хувьсах зардал

Bi – тээвэр шатахууны нийт зардал

Si – багийн бага эмчийн хөлс

Ci – гэрээт ажлын хөлс

i – тухайн сум

3.2 Суурь зардал (*MCi*):

3.2.1 Суурь зардалд тээвэр шатахууны зардлаас бусад хувьсах зардал хамаарна.

3.2.2 Суурь зардлын бүрэлдэхүүн хэсэг, түүний зардлын хэмжээ нь Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн захиргааны байгууллагуудын шийдвэрээр өөрчлөгдөх нөхцөл үүссэн тохиолдолд суурь зардлыг Эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран шинэчлэн батална.

3.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал (*FCi*):

3.3.1 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмжээг тухайн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн байрлаж буй байрны түлш халаалт, цэвэр ус, бохир ус, гэрэл цахилгааны жилийн нийт хэрэглээ, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөгдөж байгаа үнэ, тариф болон гүйцэтгэлд үндэслэн тооцно.

3.4 Хүн амаас хамааран нэмэгдэх хувьсах зардал (P_i)

3.4.1 “Сум, тосгоны хүн амын тооноос хамаарсан ангилал”-д харгалзуулан тогтоосон хүн амын тооноос илүү хүн ам бүрт хувьсах зардлын нэмэгдлийг суурь зардалд нэмэгдүүлэн олгоно. Хүн амаас хамааран нэмэгдэх хувьсах зардлыг дараах аргачлалаар тооцно.

$$P_i = (Pop_i - ST_i) * VC$$

P_i – хүн амаас хамааран нэмэгдэх нийт хувьсах зардлын хэмжээ

Pop_i – тухайн сумд оршин суугаа хүн амын тоо

ST_i – тухайн сум, тосгоны хүн амын тооноос хамаарсан ангилалд харгалзуулан тогтоосон хүн амын тоо

VC – хүн амаас хамаарах хувьсах зардлын хэмжээ

i – тухайн сум

3.4.2 Сум, тосгоны хүн амын тооноос хамааруулан сум, тосгоны эрүүл мэндийн төвийг дараах байдлаар ангилна.

Сум, тосгоны хүн амын тооноос хамаарсан ангилал	Сум, тосгоны хүн амын тооноос хамаарсан ангилалд харгалзуулан тогтоосон хүн амын тоо (ST_i)
Ангилал I	2000 хүртэлх хүн амтай
Ангилал II	2001- 3000 хүн амтай
Ангилал III	3001-ээс 4500 хүн амтай
Ангилал IV	4501-ээс дээш хүн амтай

3.5 Тээвэр шатахууны зардал (B_i):

3.5.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тээвэр, шатахууны зардлыг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний ачаалал, газар нутгийн онцлог байдлыг харгалзан дараах аргачлалаар тооцно.

B_i = Алслалт тооцсон шатахууны зардал + Үйлчлэх хүрээний радиус тооцсон шатахууны зардал + Хүн амаар тооцсон шатахууны зардал + Замын бартааг тооцсон шатахууны зардал

B_i – жилийн нийт тээвэр шатахууны зардал

3.5.2 Алслалт тооцсон шатахууны зардал нь нийт шатахууны зардлын 30 хувийг эзлэх бөгөөд дараах аргачлалаар тооцно.

$$\text{Алслалт тооцсон шатахууны зардал } i = P * N_{11} + Z * 0.3$$

P – тээвэр шатахууны суурь зардал

N_{11} – сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс аймгийн төв хүртэлх зайн харгалзах индекс

Z – тухайн оршин байгаа нутаг дэвсгэрийн шатахууны үнээс хамаарсан бүсийн нэмэгдлийн индекс

3.5.2.1 Сум тосгоны эрүүл мэндийн төвөөс аймгийн төв хүртэлх зайн харгалзах индекс (N_{i1}) гэдэг нь энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан индекс болно.

3.5.2.2 Алслалтаас хамаарсан индексийг дараах аргачлалаар тооцно.

$$Ds_i = \frac{D_i}{D}$$

Ds_i – сумын эрүүл мэндийн төвийн тээвэр шатахууны зардал тооцох алслалтын индекс

D_i – сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс аймгийн төв хүртэлх зай /км/

D – нийт сум, тосгоны дундаж алслалт (100 км)

3.5.2.3 Тухайн оршин байгаа нутаг дэвсгэрийн шатахууны үнээс хамаарсан бүсийн нэмэгдлийн индекс (Z)-ийг доорхи коэффициентээр тооцно.

Төвийн бүс - 1.0

Зүүн бүс – 1.1

Хангайн бүс – 1.2

Баруун бүс -1.4

3.5.3 Үйлчлэх хүрээний радиус тооцсон шатахууны зардал нь нийт шатахууны зардлын 30 хувийг эзлэх бөгөөд дараах аргачлалаар тооцно.

Үйлчлэх хүрээний радиус тооцсон шатахууны зардал $= P * R_{si} * 0.3$

P – тээвэр тээвэр тээвэр шатахууны суурь зардал

R_{si} – сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс

3.5.3.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс (R_{si}) -ийг тооцохдоо сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний радиусыг нийт сум, тосгонуудын үйлчлэх хүрээний радиусын дундаж хэмжээнд харьцуулж тооцно.

$$Rs_i = \frac{R_i}{R}$$

Rs_i – сумын эрүүл мэндийн төвийн тээвэр шатахууны зардал тооцох үйлчлэх хүрээний радиусаас хамаарсан индекс:

R_{si} – сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний зай /км/

R – үйлчлэх хүрээний дундаж радиус (100 км)

3.5.4 Хүн амаар тооцсон шатахууны зардал нь нийт шатахууны зардлын 20 хувийг эзлэх бөгөөд дараах аргачлалаар тооцно.

Хүн амаар тооцсон шатахууны зардал = $P * Pop_{si} * 0.2$

P – тээвэр шатахууны суурь зардал

Pop_{si} – сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүн амаас хамаарсан индекс

- 3.5.4.1 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүн амын тооноос хамаарсан индекс (*Pop_{si}*) -ийг тооцохдоо тухайн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүн амын тоог нийт сум, тосгоны хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

$$Pop_{si} = \frac{Pop_i}{P}$$

Pop_{si} – сумын эрүүл мэндийн төвийн тээвэр шатахууны зардал тооцох хүн амын тооноос хамаарсан индекс

Pop_i - тухайн сум, тосгоны хүн амын тоо

P - үйлчлэх хүн амын дундаж (3114)

- 3.5.5 Замын бартааг тооцсон шатахууны зардал нь нийт шатахууны зардлын 20 хувийг эзлэх бөгөөд дараах аргачлалаар тооцно.

Замын бартааг тооцсон шатахууны зардал = $P * Os_i * 0.2$

P – тээвэр шатахууны суурь зардал

Os_i - сум, тосгоны эрүүл мэндийн төвийн замын бартаанаас хамаарсан индекс

- 3.5.5.1 Тээвэр шатахууны суурь зардал (*P*)-ыг шатахууны үнийн инфляцитай уялдуулан Эрүүл мэндийн болон Санхүүгийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүд шинэчлэн тогтооно.
- 3.5.5.2 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн замын бартаанаас хамаарсан индекс (*Os_i*) гэдэг нь энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан индекс болно. Уг индексийг тооцохдоо үйлчлэх хүрээний газар нутгийн замын бартаа, өндөрлөг байдлыг харгалзаж, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот тушаалын 7-р хавсралт “Автомашин шатахуун зарцуулалтыг тооцох заавар” аргачлалыг баримтлан тухайн сум, тосгоны газар нутгийн далайн түвшнээс дээш өргөгдсөн өндрийг нийт сум, тосгонуудын дундаж өндөрт харьцуулж тооцно. Замын бартаанаас хамаарсан индексийг дараах томъёогоор тооцоолно.

$$O s_i = \frac{O_i}{O}$$

$O s_i$ – сумын эрүүл мэндийн төвийн тээвэр шатахууны зардал тооцох хүн амын тооноос хамаарсан индекс

O_i - тухайн сумын далайн түвшнээс дээш өргөгдсөн өндөр (м)

O - далайн түвшнээс дээш өргөгдсөн өндрийн дундаж (1381 м)

3.5.6 Тээвэр шатахууны зардлын хэмжээг тооцоход ашиглагдаж буй индексүүд болох (N_{i1}), ($R s_i$), (Pop_{s_i}) -ийн хэмжээ нь 1-ээс бага бол тухайн индексүүдийн нөлөөллийг тооцохгүйгээр тээвэр шатахууны суурь зардал (P)-аар олгоно.

3.6 Багийн бага эмчийн хөлс (s_i):


3.6.1 Багийн бага эмчийн хөлсийг “Төрийн албан хаагчийн цалин хөлсний жишиг” тогтоосон Засгийн газрын тогтоол болон холбогдох нэмэгдэл, урамшууллын тогтоол шийдвэрүүдийг үндэслэн тооцно.

3.7 Гэрээт ажлын хөлс (c_i):

3.7.1 Гэрээт ажлын хөлсний бүрэлдэхүүнд байгууллагыг дулаанаар хангах үйл ажиллагааны зардал (Тухайлбал: галчийн цалин, хөлс) хамрагдана.

Дөрөв. Бусад


- 4.1 Баг, хороо, сум, дүүргийн засаг дарга нь нутаг дэвсгэрийн хүн амын тоог үнэн зөв гаргах үүрэг хүлээнэ.
- 4.2 Төсвийн шууд захирагч мэдээллийг үндэслэн энэхүү аргачлалын дагуу төсвийг тооцон дээд шатны байгууллагуудад хүргүүлнэ.
- 4.3 Төсвийн байгууллага нь батлагдсан санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахба зориулалт бусаар бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.
- 4.4 Тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь зайлшгүй шаардлагатай тохиолдолд Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төсөвт байгууллагуудын зөвшилцлөөр урсгал зардлын төсөвт өөрчлөлт оруулж батлуулж болно.
- 4.5 Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь дээд шатны байгууллагаас нэмэлт санхүүжилт авч болно.
- 4.6 Орон тооны нормативыг тухайн орон нутгийн онцлог болон бусад харгалзах үзүүлэлтийг үндэслэн төсвийн шууд захирагч төсөвтөө багтаан зохицуулалт хийж болно.
- 4.7 Зайлшгүй нөхцөл байдлын улмаас /онцгой болон гамшиг/ төсөвт зардлыг нэмэгдүүлэх асуудлыг дээд шатны болон орон нутгийн бусад байгууллагаас санхүүгийн дэмжлэг авч болно.



СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН СУУРЬ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

/ мянган төгрөгөөр/


Утга	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүн амын тооноос хамаарсан ангилал			
	Ангилал I	Ангилал II	Ангилал III	Ангилал IV
Суурь зардал (MCI)	169,317.9	196,030.5	229,986.2	287,921.2
Тээвэр шатахууны суурь зардал(P)			9,000.0	
Хүн амаас хамаарах хувьсах зардал (VC)			8.865	



Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын
 2015 оны 12 дугаар сарын 21 өдрийн
 498/245 дугаар хамтарсан тушаалын
 3 дугаар хавсралт

СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ОРОН ТООНЫ НОРМАТИВ

Утга	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хүн амын тооноос хамаарсан ангилал			
	Ангилал I	Ангилал II	Ангилал III	Ангилал IV
Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн орон тооны норматив				
- эмч	2	3	4	5
- сувилагч	5	6	7	8
- бага эмч	4	4	4	5
- бусад(жолооч, тогооч, үйлчлэгч, ариутгагч)	4	4	5	7
- багийн бага эмч	Сумын засаг захиргааны багийн тоо болон онцлогоос хамаарч			



Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын
2015 оны 12 дугаар сарын 21 өдрийн
198/345 дугаар хамтарсан тушаалын
4 дүгээр хавсралт

**СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ШАТАХУУНЫ ЗАРДАЛ ТООЦОХОД
АШИГЛАГДАХ ИНДЕКС**

№	Аймаг, нийслэлийн нэр	Сум, тосгоны нэр	Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс аймгийн төв хүртэлх зайн харгалзах индекс(N_{ij})	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн замын бартаанаас хамаарсан индекс (O_{Si})
1.1	1.Улаанбаатар хот	Туул тосгон	0.37	0.87
1.2		Жаргалант тосгон	0.67	0.84
1.3		Хонхор тосгон	0.22	0.96
1.4		Гачуурт тосгон	0.17	1.02
2.1	2.Архангай аймаг	Батцэнгэл	0.71	1.04
2.2		Булган	0.37	1.39
2.3		Жаргалант	2.27	1.17
2.4		Ихтамир	0.27	1.22
2.5		Өгийнуур	1.00	0.98
2.6		Өлзийт	1.34	0.94
2.7		Өндөр-Улаан	1.22	1.65
2.8		Төвшрүүлэх	0.44	1.17
2.9		Хайрхан	1.75	1.44
2.10		Хангай	2.30	1.54
2.11		Хашаат	1.78	0.94
2.12		Хотонт	0.91	1.06
2.13		Цахир	3.06	1.53
2.14		Цэнхэр	0.29	1.54
2.15		Цэцэрлэг	2.12	1.22
2.16		Чулуут	1.27	1.47
2.17		Хоршоолол/Эрдэнэбулган сум/	0.45	1.19
3.1	3.Баян-Өлгий аймаг	Алтай	1.12	1.56
3.2		Алтанцөгц	0.43	1.36
3.3		Баяннуур	1.26	0.98
3.4		Бугат	0.05	1.42
3.5		Булган	2.94	1.41
3.6		Буянт	0.72	1.42
3.7		Сагсай	0.27	1.62
3.8		Толбо	0.76	1.39
3.9		Улаанхус	0.46	1.28

3.10		Хөх хөтөл /Улаанхус Их эмчийн салбар/	1.10	1.28
3.11		Цагааннуур тосгон /Ногоон нуур сум/	0.69	1.07
3.12		Хотгор/Өлгийн сумын багийн эмчийн салбар/	1.40	1.24
4.1	4.Баянхонгор аймаг	Баацагаан	1.40	0.96
4.2		Баянбулаг	2.66	1.64
4.3		Баянговь	2.45	1.17
4.4		Баянлиг	2.18	0.97
4.5		Баян-Овоо	0.26	0.97
4.6		Баян-Өндөр	2.76	1.72
4.7		Бөмбөгөр	1.00	1.46
4.8		Бууцагаан	1.74	1.42
4.9		Галуут	0.95	1.54
4.10		Гурванбулаг	2.44	1.76
4.11		Жинст	1.00	1.02
4.12		Заг	1.88	0.96
4.13		Өлзийт	0.18	0.94
4.14		Хүрээмарал	2.13	1.51
4.15		Шинэжинст	2.65	1.61
4.16		Эрдэнэцогт	0.28	1.52
4.17			Шаргалжуут/Баянхонгор сум 8-р баг/	0.60
5.1	5.Булган аймаг	Баян-Агт	1.50	1.12
5.2		Баяннуур	1.80	0.70
5.3		Бугат	0.55	0.85
5.4		Бүрэгхангай	0.85	0.94
5.5		Гурванбулаг	1.50	0.79
5.6		Дашинчилэн	1.53	0.77
5.7		Могод	1.32	1.04
5.8		Орхон	0.22	0.77
5.9		Рашаант	2.25	0.99
5.10		Сайхан	1.01	1.07
5.11		Сэлэнгэ	1.20	0.55
5.12		Тэшиг	2.45	0.74
5.13		Хангал	1.10	0.75
5.14		Хялганат/Хангал сум/	1.3	0.75
6.1	6. Говьсүмбэр аймаг	Баянтал	0.60	0.78
6.2		Шивээговь	0.86	0.81
7.1	7.Говь-Алтай аймаг	Алтай	3.60	1.58
7.2		Бугат	2.05	1.55
7.3		Дарви	2.10	1.18
7.4		Дэлгэр	1.00	1.30
7.5		Жаргалан	0.97	1.12
7.6		Тайшир	0.45	1.20
7.7		Тонхил	2.10	1.59
7.8		Халиун	1.10	1.05
7.9		Хөхморьт	2.15	1.04
7.10		Цогт	2.00	0.86
7.11		Цээл	1.80	1.51

7.12		Чандмана	2.26	1.66
7.13		Шарга	0.89	0.74
7.14		Эрдэнэ	2.53	1.77
7.15		Баянтоорой тосгон	2.60	1.22
7.16		Гуулин тосгон	0.90	1.25
8.1	8. Дархан-Уул аймаг	Орхон	1.00	0.46
8.2		Хонгор	0.44	0.52
8.3		Шарын гол	1.50	0.66
9.1	9. Дорноговь аймаг	Айраг	1.27	0.76
9.2		Алтанширээ	0.90	0.70
9.3		Даланжаргалан	1.56	0.90
9.4		Дэлгэрэх	1.40	0.77
9.5		Иххэт	1.80	0.87
9.6		Мандах	1.75	0.84
9.7		Өргөн	0.60	0.71
9.8		Сайхандулаан	0.98	0.91
9.9		Улаанбадрах	1.35	0.72
9.10		Хатанбулаг	2.45	0.82
9.11		Хөвсгөл	1.76	0.72
9.12		Эрдэнэ	1.06	0.72
10.1	10. Дундговь аймаг	Адаацаг	1.04	1.07
10.2		Баянжаргалан	1.58	0.90
10.3		Гурвансайхан	0.71	0.84
10.4		Дэлгэрхангай	1.35	1.07
10.5		Дэлгэрцогт	0.45	0.89
10.6		Дэрэн	1.68	0.94
10.7		Луус	0.55	1.05
10.8		Өлзийт	1.00	0.90
10.9		Өндөршил	1.85	0.85
10.10		Сайхан овоо	2.10	0.95
10.11		Хулд	0.90	0.97
10.12		Цагаандэлгэр	1.50	0.99
10.13		Сайнцагаан	0.40	1.01
11.1	11. Орхон аймаг	Жаргалант	1	0.76
12.1	12. Өвөрхангай аймаг	Баруун-Баян-Улаан	1.75	0.91
12.2		Бат-Өлзий	1.24	1.22
12.3		Баянгол	0.80	1.06
12.4		Баян-Өндөр	1.22	1.17
12.5		Богд	1.97	1.10
12.6		Бүрд	1.36	1.08
12.7		Гучин ус	1.04	1.07
12.8		Зүүн-Баян-Улаан	0.47	1.35
12.9		Нарийн тээл	1.35	1.32
12.10		Өлзийт	0.88	1.36
12.11		Сант	1.00	1.11
12.12		Тарагт	0.35	1.11
12.13		Төгрөг	0.95	1.02
12.14		Уянга	0.61	1.44
12.15		Хайрхандулаан	0.72	1.36
12.16		Хужирт	0.84	1.20

13.1	13. Хэнтий аймаг	Батноров сум	1.05	0.76
13.2		Батширээт сум	1.96	0.81
13.3		Баян-Адарга сум	1.56	0.75
13.4		Баянмөнх сум	1.00	0.81
13.5		Баян-Овоо сум	1.43	0.67
13.6		Баянхутаг сум	0.27	0.75
13.7		Галшар сум	1.40	0.86
13.8		Дадал сум	2.80	0.72
13.9		Дархан сум	1.45	0.92
13.10		Дэлгэрхаан сум	1.38	0.90
13.11		Жаргалтхаан сум	1.00	0.97
13.12		Мөрөн сум	0.30	0.96
13.13		Норовлин сум	2.06	0.75
13.14		Өмнөдэлгэр сум	1.40	0.96
13.15		Цэнхэрмандал сум	1.45	1.04
13.16		Өлзийт /тосгон/	0.51	0.96
13.17		Хурх/гурванбаян тосгон/	1.20	0.88
13.18		Тахилгат /тосгон/	0.50	0.82
13.19		Хэрлэн баян-Улаан /тосгон/	1.61	0.87
14.1	14. Өмнөговь аймаг	Баяндалай	1.27	1.13
14.2		Баяновоо	0.90	0.86
14.3		Булган	1.56	0.60
14.4		Гурвантэс	1.40	1.25
14.5		Мандал-Овоо	1.80	0.78
14.6		Манлай	1.75	0.95
14.7		Номгон	0.60	1.08
14.8		Сэврэй	0.98	1.24
14.9		Ханхонгор	1.35	0.91
14.10		Хүрмэн	2.45	1.33
14.11		Цогт-Овоо	1.76	1.08
15.1	15. Сүхбаатар аймаг	Асгат	0.48	0.76
15.2		Баяндэлгэр	1.45	0.80
15.3		Дарьганга	1.70	0.90
15.4		Мөнххаан	1.08	0.89
15.5		Наран	2.12	0.90
15.6		Сүхбаатар	0.80	0.65
15.7		Түвшинширээ	1.40	0.80
15.8		Түмэнцогт	1.40	0.71
15.9		Уулбаян	0.55	0.75
15.10		Халзан	0.68	0.76
15.11		Эрдэнэцагаан	2.20	0.78
16.1	16. Сэлэнгэ аймаг	Алтанбулаг	0.25	0.67
16.2		Баруунбүрэн	2.20	0.66
16.3		Баянгол	1.65	0.59
16.4		Хушаат	1.10	0.48
16.5		Дулаанхаан /тосгон/	0.46	0.45
16.6		Зүүнбүрэн	0.50	0.46
16.7		Хэрх /тосгон/	2.10	0.61
16.8		Орхон	1.80	0.55
16.9		Орхонтуул	2.20	0.60

16.10		Номгон /тосгон/	1.60	0.59
16.11		Сант	2.20	0.62
16.12		Ерөө	0.92	0.49
16.13		Хүдэр	1.60	0.51
16.14		Түнхэл /тосгон/	2.65	0.64
16.15		Цагааннуур	1.00	0.57
16.16		Шаамар	0.21	0.45
16.17		Рашаант/тосгон/	2.00	0.63
16.18		Түшиг	1.30	0.54
16.19		Жавхлант	0.72	0.68
16.20		Бугант /тосгон/	1.30	0.59
17.1	17. Төв аймаг	Алтанбулаг	0.51	0.88
17.2		Аргалант	1.31	0.90
17.3		Архуст	1.13	0.84
17.4		Батсүмбэр	1.35	0.84
17.5		Баян	0.78	1.03
17.6		Баяндэлгэр	1.06	0.90
17.7		Баянжаргалан	1.41	1.00
17.8		Баян-Өнжүүл	1.31	0.88
17.9		Баянхангай	1.53	0.89
17.10		Баянцагаан	1.12	0.99
17.11		Баянцогт	1.38	0.90
17.12		Баянчандмана	1.11	0.91
17.13		Борнуур	1.44	0.74
17.14		Бүрэн	1.92	0.92
17.15		Дэлгэрхаан	2.46	1.13
17.16		Жаргалант	1.71	0.73
17.17		Заамар	2.26	0.84
17.18		Лүн	1.75	0.73
17.19		Мөнгөнморьт	1.94	1.04
17.20		Өндөрширээт	2.31	0.75
17.21		Сүмбэр	2.06	0.77
17.22		Сэргэлэн	0.14	0.83
17.23		Угтаал	1.99	0.84
17.24		Цээл	2.22	0.77
17.25		Эрдэнэ	0.83	1.14
17.26		Эрдэнэсант	2.61	0.99
18.1	18. Хөвсгөл аймаг	Алаг-Эрдэнэ	0.63	1.14
18.2		Арбулаг	0.71	1.37
18.3		Баянзүрх	1.27	1.18
18.4		Бүрэнтогтох	0.51	0.98
18.5		Галт	1.67	1.30
18.6		Жаргалант	1.77	1.29
18.7		Рашаант	1.54	1.00
18.8		Ренчинлхүмбэ	2.43	1.15
18.9		Тариалан	1.60	1.10
18.10		Тосонцэнгэл	0.64	0.94
18.11		Төмөрбулаг	0.73	1.06
18.12		Түнэл	0.46	1.10
18.13		Ханх	3.41	1.19
18.14		Цагааннуур	2.52	1.13

18.15		Цагаан-Үүр	1.73	1.19
18.16		Цэцэрлэг	2.09	1.27
18.17		Чандмана-Өндөр	1.37	1.39
18.18		Эрдэнэбулган	1.60	0.83
19.1	19. Ховд аймаг	Алтай	3.00	0.95
19.2		Буянт	0.25	0.86
19.3		Дарви	2.20	1.07
19.4		Дөргөн	1.00	0.86
19.5		Дуут	0.80	1.65
19.6		Зэрэг	1.41	0.83
19.7		Манхан	0.80	0.98
19.8		Мөнххайрхан	1.56	1.52
19.9		Мянгад	0.45	0.85
19.10		Үенч	3.65	0.98
19.11		Ховд	0.33	1.24
19.12		Цэцэг	2.32	1.16
19.13		Чандмана	1.60	1.20
19.14		Эрдэнэбүрэн	0.62	0.92
20.1	20. Завхан аймаг	Алдархаан сум	0.32	1.22
20.2		Асгат сум	2.56	1.25
20.3		Баянтэс сум	2.90	1.03
20.4		Баянхайрхан сум	2.55	1.35
20.5		Дөрвөлжин сум	1.43	1.01
20.6		Идэр сум	0.75	1.42
20.7		Их-Уул сум	2.24	1.20
20.8		Нөмрөг сум	1.52	1.34
20.9		Отгон сум	1.28	1.56
20.10		Сантмаргац сум	2.92	1.14
20.11		Сонгино сум	2.32	1.32
20.12		Тэлмэн сум	1.22	1.31
20.13		Тэс сум	3.37	0.93
20.14		Ургамал сум	2.36	0.92
20.15		Цагаанхайрхан сум	0.44	1.32
20.16		Цагаанчулуут сум	0.97	1.55
20.17	Цэцэн-Уул сум	2.47	1.40	
20.18	Эрдэнэхайрхан сум	1.15	1.37	
20.19	Яруу сум	0.56	1.52	
21.1	21. Увс аймаг	Бөхмөрөн	1.80	0.89
21.2		Даягт	1.47	0.62
21.3		Завхан	1.80	0.76
21.4		Зүүнговь	1.40	0.72
21.5		Зүүнхангай	3.50	1.30
21.6		Мапчин	1.05	1.06
21.7		Наранбулаг	0.90	0.82
21.8		Өлгий	1.11	1.14
21.9		Сагил	0.67	0.82
21.10		Тариалан	0.34	0.68
21.11		Түргэн	0.37	0.88
21.12		Тэс	1.80	0.58
21.13		Ховд	1.86	0.87
21.14		Хяргас	1.65	0.99

21.15		Цагаанхайрхан	2.40	1.27
22.1	22. Дорнод аймаг	Баяндун	1.80	0.68
22.2		Баянтүмэн	0.15	0.56
22.3		Булган	0.60	0.57
22.4		Гурванзагал	1.30	0.51
22.5		Магад	1.50	0.65
22.6		Сэргэлэн	0.70	0.55
22.7		Хөлөнбуйр	1.30	0.62
22.8		Цагаан-Овоо	1.30	0.62
22.9		Чойбалсан	0.60	0.62
22.10		Чулуунхороот	2.65	0.45